

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

Том. XXXI (328)

2010

54-60

АЛТАЙ ХЭЛНИЙ ЗАРИМ ДАГАВАР, НӨХЦӨЛИЙН
ХЭЛЗҮЙН УТГА, ҮҮРГИЙН ОНЦЛОГ

Г.Буяントогтох¹

Орчин үеийн хэлшинжлэлийн онолын үндэслэлд тулгуурлан, алтай хэлний нэгэн бүлэг бүтээврийн хэлзүйн утга, үүргийн онцлогийг тодруулахад, уул бүтээвэрт дагаврын шинж давамгай байгаа тул тэдгээрийг төрлийн нэрээс хэсгийн нэр үүсгэх дагавар гэж нэрлэсэн билээ. Үүнд,

Казах хэлний *-лар, -лер, -дар, -дер, -тар, -тер;*

Манж хэлний *-са, -сэ, -си, -со, -та, -тэ, -ри*

Орчин цагийн монгол хэлний *-нар, -нэр, -чуюд, -чүүд, -чуул, -чүүл, -нууд, -нууд, -ууд, -үүд, -д, -с* бүтээвэр болон эдгээртэй харгалзах нийт түрэг, хамниган, монгол болон наран, солонгос хэлний бүтээвэр доорхи шинжтэй учраас үг хувилгах нөхцөл бус, харин үг бүтээх дагавар болж байгаа юм. Тодруулбал,

1.Дурдсан бүтээвэр залуу + с = залуус - жас + тар = жастар - асихан + та = асихата; нялх + с = нялхас - сэби + лер = сэбителр - хүхүри + са = хүхүри са; өвгөн + д = өвгөд - карт + тар = қарттар - мафа + ри = мафари; эмгэн + д = эмгэд - эже + лер = эжелер - мама + ри = мамари гэх мэтээр язгуурын дараа шууд залган орж, хүний хамаатай нэр үүсгэж байгаа учраас нөхцөл бус, үг бүтээх дагавар болж байна. Энэ жишээнд байгаа залуу, нялх, өвгөн, эмгэн зэрэг үг цөм тэмдэг нэр бөгөөд эдгээрийн ард хүн гэдэг үг байснаа хэлний хэмнэх ёсны дагуу гээгдэн, эдгээр тэмдэг нэр, ялангуяа өвгөн, эмгэн гэдэг хоёр үг ихээхэн нэршиж, нэр үгийн үүрэг хүлээх болжээ.

2.Дурдсан бүтээвэр бүтээлч биш учраас бүх язгууртай холбогдохгүй, зөвхөн өөрийн гэсэн цөөн хэдэн язгууртай холбогдох, хэсгийн нэр үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, орчин цагийн монгол хэлний *-нар, -нэр* дагавар хүний хамаатай төрлийн нэрд; *-чуюд, -чүүд, -чуул, -чүүл* дагавар үндсэн утгаараа бол тэмдэг нэрд; казах хэлний *-лар, -лер* дагавар эгшиг болон *p* төгсгөлтэй үгэнд; *-дар, -дер* дагавар *л, м, н, и, ү*, з төгсгөлтэй үгэнд; *-тар, -тер* дагавар *б, п, г, ү, к, үүд, т, с, ш* төгсгөлтэй үгэнд; манж хэлний *-ри* дагавар мафа, мама гэдэг хоёр үгэнд; *-та, -тэ* дагавар хүний хамаатай цөөн үгэнд; *-са, -сэ, -си, -со* дагавар дээрх дагавруудыг залгаж болдоггүй бусад нэр, тэгэхдээ зөвхөн хүний хамаатай нэрд тус тус залгагддаг. Монгол хэлний *-ууд, -үүд, -д, -с, -нууд, -нууд* дагавар хүн, хүн бусын нэрд залгагдана. Гэхдээ нэг дагаврын байранд нөгөө дагавар үл тохиолдоно.

¹ Доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Казах хэлний *-лар*, *-лер*, *-дар*, *-дер*, *-тар*, *-тер* бүтээврийн тухайд дээр дурдсан тайлбар, жишээ нэг талаас зөв бичих зүйн асуудал боловч, нөгөө талаас эдгээр бүтээврийг монгол хэлний *-ууд*, *-үүд*, *-д*, *-с,-нууд,-нүүд*, *-чууд*, *-чүүд*, *-чуул*, *-чүүл*; манж хэлний *-та*, *-тэ*, *-са*, *-сэ*, *-си*, *-со* бүтээврийн нэгэн адилаар жинхэнэ нэрээс гадна тэмдэг нэр, орон цагийн харилцааны нэр зэрэг бусад аймгийн үтийн залгаж жинхэнэ нэр үүсгэж болдог онцлогтойг доорхи жишээнээс мэдэж болно. Үүнд, *озат* - *тэргүүний*, *сайн* - *озаттар* - *сайчууд*; *аргы* - *зах*, *дээд тал* - *аргылар* - *дээдүүл*, *дээдэс*; *элгি* - *нөгөө*, *өнөө* - *элгилер* - *нөгөөдүүл*, *өнөөдүүл* гэх мэт. Эдгээр жишээний *озаттар* - *сайчууд* гэдэг тэмдэг нэрээс, *аргылар* - *дээдүүл*, *дээдэс* гэдэг орон цагийн харилцааны нэрээс, *элгилер* - *нөгөөдүүл*, *өнөөдүүл* гэдэг төлөөний үгээс тус тус үүсчээ.

Тийм учраас казах хэлний *-лар*, *-лер*, *-дар*, *-дер*, *-тар*, *-тер* бүтээвэр манж, монгол зэрэг бусад алтай хэлний дурдсан бүтээврийн адилаар уг бүтээх дагаврын шинж илүүтэй бөгөөд энэ онцлогоороо орос, европ хэлний нэр үгийн тооны айн нөхцөлөөс ялгаатай байна.

3.Нэг нэр үгийг эдгээр бүлэг бүтээвэрт багтаж байгаа бүх дагавраар хувилгаж болохгүй.

4.Эдгээр бүтээврийг идэвхгүй язгуурт залгаж болдог. Жишээл-бэл, *баячууд* - *байлар* - *байаса*; *эд* - *булар* - *эсэ*; *тэд* - *олар* - *тэсэ* гэх мэт.

5.Юм, түүний үйл хөдлөлийн хоорондын хамаарлыг захирах, захицуулах харилцаанд тулгуурлан илэрхийлэх боломж эдгээр бүтээвэрт байхгүй учраас дагавар болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, эдгээр бүтээврийг авсан уг зөвхөн нэрлэх дохио болно.

6.Эдгээр бүтээврийг нэг язгуур юм уу үндсэнд орлуулан залгаж, хам цэгийн харилцаа үүсгэж болохгүй учраас дагавар гэж үзэж байгаа юм. Үүнд,

Алтайн олон хэлний нэр уг дээр дурдсан бүтээврийг аваагүй, язгуур юм уу үндсийн хэлбэрээр байхдаа тухайн төрөл зүйл юмын бүгдийн нэр болж байдаг бөгөөд уул бүлэг бүтээврийн аль тохирохыг авмагцаа тухайн төрөл зүйл юмын нэгэн хэсгийн нэр болдог. Энэ шинжийг нь харгалзан алтай хэлний нэр үгийг ангилбал:

1.Хүний хамаатай нэр.

Казах:*адам*, *әке*, *моңгол*, *қарт*, *ага*, *әпеке*, *немере*, *адамдар*, *әкелер*,*моңголдар*,*қарттар*,*агалар*,*әпекелер*, *нemereler*

Манж:*нийалма*,*ама*,*монго*,*мафа*, *ахун*, *эйүн*, *омоло*, *нийалма* *са*, *амата*,*монгосо*,*мафари*,*ахута*,*омоси*,*эйүтэ*

Монгол:*хүн*,*аав*,*монгол*,*өвгөн*, *ах*, *эгч*, *ач* (*хүүхэд*), *хүмүүс*, *аав* *нар*,*монголчууд*,*өвгөд*,*ахнар*,*эгчинэр*,*ачнар*

1.1.Хүний хамаатай төрлийн нэр.

Казах:*адам*, *әке*, *моңгол*, *қарт*, *ага*, *әпеке*, *немере*

Манж: *нийалма*, *ама*, *монго*, *мафа*, *ахун*, *эйүн*, *омоло*

Монгол: *хүн*, *аав*, *монгол*, *өвгөн*, *ах*, *эгч*, *ач* (*хүүхэд*)

1.2.Хүний хамаатай хэсгийн нэр.

Казах:*адамдар*,*әкелер*,*моңголдар*,*қарттар*,*агалар*,*әпекелер*, *нemereler*

Манж: *нийалма* *са*,*амата* ,*монгосо*,*мафари*,*ахута*,*эйүтэ*, *омоси*

Монгол: хүмүүс, аав нар, монголчууд, өвөгөд, ах нар, эгч нэр, ач нар

2.Хүн бусын нэр.

Казах: құс, ағаш, мал, төл, ғұл, әріп, сөз, мас, құстар, ағаштар, малдар, төлдер, ғұлдер, әріппер, сөздер, мастар

Манж: гасха, моо, улха, фұрсун, илха, хәргэн, гисун, вәхә

(Харин манж хэлэнд хүн бусын нэрнээ төрлийн нэрээс хэсгийн нэр үүсгэх дагавар залгах нийлтэг арга хэрэг-лэдэггүй.)

Монгол: шувуу, мод, мал, төл, цэцэг, үсэг, уг, чулуу, шувууд, моднууд, малууд, төлүүд, цэцүүд, үсгүүд, угс, чулуунууд

2.1.Хүн бусад хамаатай төрлийн нэр.

Казах: құс, ағаш, мал, төл, ғұл, әріп, сөз, мас

Манж: гасха, моо, улха, фұрсун, илха, хәргэн, гисун, вәхә

Монгол: шувуу, мод, мал, төл, цэцэг, үсэг, уг, чулуу

2.2.Хүн бусад хамаатай хэсгийн нэр.

Казах: құстар, ағаштар, малдар, төлдер, ғұлдер, әріппер, сөздер, мастар

Монгол: шувууд, моднууд, малууд, төлүүд, цэцүүд, үсгүүд, угс, чулуунууд

Алтай хэлний хэсгийн нэр доорхи дагавраар үүсдэг. Үүнд,

1.Казах, түрэг хэлний хэсгийн нэр үүсгэх дагавар:

а. **-лар, -лер дагавар**

азербайжан, алтай, балкар, башкир, гагауз, казах, караим, каракалпак, киргиз, кумык, ногай, салар, татар, тофалар, тува, түрк, түркмен, түрэг, уйгур, үзбек, хакас, шар уйгур, шор, якут хэлэнд байдаг.

б. **-лор, -лөр дагавар**

киргиз, ногай, түркмен, якут хэлэнд байдаг.

в. **-нар, -нер дагавар**

кумык, киргиз, ногай, гагауз, шор, якут, хакас, түркмен, шар уйгур, тува, тофалар хэлэнд бий.

г. **-нор, -нөр дагавар**

киргиз, ногай, түркмен, якут хэлэнд байдаг.

д. **-дар, -дер дагавар**

алтай, башкир, казах, каракалпак, киргиз, тува, түркмен, шар уйгур, якут хэлэнд байдаг.

е. **-дор, -дор дагавар**

киргиз, түркмен, якут хэлэнд байдаг.

ё. **-тар, -тер дагавар**

алтай, башкир, казах, каракалпак, киргиз, тува, түркмен, хакас, шар уйгур, шор, якут хэлэнд байдаг.

ж. **-тор, -төр дагавар**

киргиз, түркмен, якут хэлэнд байдаг.

з. **-зар, -зер дагавар** башкир хэлэнд байдаг.

и. **-ар, -ер дагавар** чуваш хэлэнд байдаг.

2. Манж-хамниган хэлний хэсгийн нэр үүсгэх дагавар:

- а. *-са, -сэ, -си, -со, -та, -тэ, -ри дагавар* манж, шивээ хэлэнд,
- б. *-сал дагавар* орок, орончон, нанай, ульч, хамниган, эвен, негидал, со лоон хэлэнд,
- в. *-сил дагавар* орок, нанай, ульч хэлэнд байдаг.
- г. *-тил дагавар* орок, ульч, хамниган, эвен, негидал хэлэнд,
- д. *-нил дагавар* негидал, хамниган, эвен хэлэнд,
- е. *-чил дагавар* орок, солоон хэлэнд,
- ё. *-рил дагавар* нанай, солоон, хамниган хэ лэнд,
- ж. *-л дагавар* нанай, негидал, орок, орончон, үдэгей, ульч, хамниган, эвен хэлэнд,
- з. *-р дагавар* хамниган, эвен хэлэнд,
- и. *-нта дагавар* орончон, үдэгей хэлэнд,
- к. *-ха, -на, -нал, -жила дагавар* үдэгей хэлэнд,
- л. *-саг дагавар* орончон хэлэнд,
- м. *-рисал, -лтад дагавар* нанай хэлэнд,
- н. *-рул дагавар* ульч хэлэнд,
- о. *-насал дагавар* хамниган хэлэнд,
- ө. *-рэл дагавар* эвен хэлэнд,
- п. *-йил дагавар* негидал хэлэнд,
- р. *-сул, -чул, -чал дагавар* солоон хэлэнд тус тус байна.

3. Монгол хэлний хэсгийн нэр үүсгэх дагавар:

- а. *-нар, -нэр дагавар* ОЦМХ, өвөр монгол, халимаг, буриад, дагуур хэлэнд байгаа бөгөөд –НОР хувилбартай.
- б. *-чууд, -чүүд дагавар* ОЦМХ, өвөр монгол, халимаг, буриад хэлэнд байдаг. Буриадад *-шууд, -шүүд* гэх ба өвөрмонголд *-чууд, -чүүд*-ээс гадна *-шууд, -шүүд* бий.
- в. *-чуул, -чүүл дагавар* ОЦМХ, буриад, өвөр монголд байх ба сүүлчийн хоёрынх *-шуул, -шүүл* хэлбэртэй.
- г. *-нууд, -нууд дагавар* ОЦМХ, өвөрмонгол, буриад, могол хэлэнд бий.
- д. *-нуус, -нуус дагавар* ОЦМХ, өвөр монгол хэлэнд байдаг.
- е. *-ууд, -үүд дагавар* ОЦМХ, өвөр монгол, буриад, халимаг, могол хэлэнд байдаг.
- ё. *-д дагавар* ОЦМХ, өвөр монгол, халимаг, буриад, могол хэлэнд байдаг.
- ж. *-с дагавар* ОЦМХ, өвөр монгол, халимаг хэлэнд байдаг.
- з. *-наад, -нэд дагавар* буриад, өвөр монголд байдаг бөгөөд буриадад бас – НОД хувилбар бий.
- и. *-мууд, -мууд дагавар* халимаг, өвөр монгол хэлэнд байдаг.
- к. *-мад, -мэд дагавар* буриад хэлэнд бий.
- л. *-дууд, -дүүд дагавар* халимаг хэлэнд бий.
- м. *-н дагавар* буриад хэлэнд байдаг.
- н. *-тан дагавар* монгор, дүншиан, буриад хэлэнд байдаг бөгөөд буриадад бас – *тэн, -тон* хувилбар бий.
- о. *-нур, -нүр, -сул, -сүл дагавар* дагуур хэлэнд байдаг.
- е. *-нгула, -сге, -се дагавар* монгор хэлэнд байдаг.
- п. *-ла дагавар* дүншиан хэлэнд байдаг.

р. -лэ *дагавар* баоань хэлэнд байдаг.

с. -т *дагавар* могол хэлэнд байдаг.

т. -гууд, -гүүд *дагавар* буриад хэлэнд байдаг.

Ийнхүү алтай хэлнүүдийн нэр үгийн тооны нөхцөл буюу тэр тусмаа олон тооны нөхцөл гэгдсээр байгаа бүлэг бүтээврийг дагаврын шинж давамгай учраас нэр үгийн үндэс үүсгэх бүтээвэр гэж үзэж байгаа юм. Ингэхдээ төрлийн нэрээс хэсгийн нэр үүсгэх дагавар гэж нэрлэж байна. Учир нь, "... үндэс үүсгэх дээр дурдсан дагавруудыг өрнөдийнхний хэлний олны дагавартай адилтгаж, уг бүтээх дагавраас салган хэлзүйн айд багтаан үздэг байна. Монгол хэлний олны дагавар нь бусад уг бүтээх дагаврын нэгэн адил үгийн үндэс үүсгэхээс гадна хийсвэр утгатай чанар, орон цагийн харьцааны нэрийг харьцааны бус нэр болгоно. Өөрөөр хэлбэл, юмын бэлгэ чанарыг заасан нэрийг бод биеийг заасан утгатай нэр болгоно. Бас тооны харьцааны нэрийг овог аймгийг нэрлэсэн бодитой нэр болгох зэргээр уг бүтээх дагаврын үүрэг гүйцэтгэх учир . . . уг бүтээх дагаврын нэг зүйл гэж үзлээ. Жишээ: бага гэхэд юмын хэмжээ заасан нэр байсан бол багачууд гэхэд бага хүүхдийг заасан нэр болох мэт.

Монгол хэлний нэрийн олныг заах дагаврыг заримдаа биеэ даасан уг болж чадахгүй үгийн идэвхгүй язгуурт залгаж, биеэ даасан нэр болгоно. Жишээ: бая-баячууд, сай-сайчууд гэх мэт”²(Лувсанвандан.1968.x.126-127).

Түүнчлэн, дурдсан бүтээвэр төрөл зүйлийн бүгдийн нэрийг мөн төрөл зүйл юмын хэсгийн нэр болгох бөгөөд утга үүргийн хувьд “ . . . үгэлбэрийн доторхи үгсийн харьцааг заадаггүй, анхдагч буюу үүсмэл үндэс үүсгэдэг тул нөхцөлийн ангид багтахгүй, харин уг бүтээх дагаврын ангид багтах ёстой . . . Монгол хэлний олны зарим дагаврыг нэр ч биш, үйл уг ч биш, цэвэр язгуурт залгаж, нэрийн үндэс үүсгэнэ. Жишээлбэл, баяд, ноёд, ноход гэх мэтчилэн үндэс болдоггүй, бая-, ноё-, нохо- гэсэн язгуурт залгаж бодит нэр үүсгэнэ. Монгол хэлний олны дагаврыг янз бүрийн харьцааны нэрд залгаж, харьцааны нэрээс үүссэн янз бүрийн бодит нэр үүсгэдэг. Жишээлбэл, наад, цаад, хойд, урд (Орон цагийн харьцааны нэрс)-наадуул, цаадуул, хойдуул, урдуул (Бодит нэрс); хар, цагаан, их, бага, илүү, дутуу (Чанарын харьцааны нэрс)-харууд, цагаанууд, ихүүд, багууд, илүүнүүд, дутуунууд (Бодит нэрс) гэх мэт. Ингэж харьцааны нэрээс олны дагавар залгаж үүсгэсэн үгс нь уул харьцааныхаа нэрийн чанарыг алдаж, бодит нэрийн чанартай болохыг хялбархан ажиглаж болно. Ингэж үүссэн бодит нэрс нь үйл үгийн өмнө, хойноо заавал минь, чинь, нь дагавар шаардахгүй, тийм дагаваргүй орлоо гэхэд жинхэнэ харьцааны нэrsийн адил утга хоёрдохгүй юм. Жишээ: бага иржээ, бага нь иржээ, багууд иржээ, багууд нь иржээ гэх мэт”³(Лувсанвандан. 2005.x.181-182) онцлогтой юм. Энэ онцлог ганцхан монгол хэлэнд хамаатай бус нийт түрэг, ялангуяа казах хэлэнд ийм байгаа бөгөөд орчин цагийн казах түрэг хэлний хэрэглэгдэхүүн болон монгол хэлний эрт эдүгээгийн жишээ баримтад энэхүү хэсгийн нэр үүсгэх дагавартай уг нэлээд байгаа нь

² Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний уг нөхцөл хоёр.УБ.1968

³ Ш.Лувсанвандан.Хэл,харьцаа,тэмдэг.УБ.2005

“ . . . “хэсэг тооны дагавар” түлхүү хэрэглэгдэж байсан нуттай баримт . . . ”

⁴(Бадмаанямбуу. 2004.x.71) болж чадахгүй, харин эдгээр хэлэнд төрлийн нэрийн зэрэгцээ хэсгийн нэр нэлээд хэрэглэдгийн гэрч баримт юм. Энэ нь орос, европ хэлтний ганц, олон тооны айтай холбоогүй, өөрөөр хэлбэл, тэдний сэтгэлгээнд хоёр юм уу түүнээс дээш тоотой л юм байвал олон гэж ухагддаг суурьшмал амьдралын хэвшилтэй нягт зууралдсан төрөлх мэдрэмж, ойлголт байдагтай монгол болон бусад алтай хэлтний хэсгийн нэр хэрэглэх байдал холбоогүй, зөвхөн тухайн төрөл зүйлийн доторхи хэсэг бүлгийг л нэрлэсэн нэр гэж ухагддаг онцлогтой бөгөөд тэр хэсэг юм олон юм уу цөөн байх нь тийм ч чухал бус байдаг. Хэрэв олон цөөнийг ялан тодруулах шаардлага тулгарвал тэр цагт нь шийдвэрлэдэг. Энэ мэт онцлог алтай хэлтэн нүүдэлчний сэтгэлгээний өвөрмөц үзэгдэл бөгөөд түүнийг тэдний үүсч бий болж өсч дэгжсэн нутаг орон, үүх түүх, байгаль дэлхийн нөхцөл байдал, аж амьдралын ахуй орчинтой нягт холbon үзэх шаардлагатай юм. Тэгвэл дээр дурдсан хэсгийн нэр хэрэглэх байдал алтай хэлтэн нүүдэлчин малчны сэтгэлгээнд он удаан жил оршин батжиж ирсэн бүлэглэг ухамсын үр дүн гэж үзэх нь зүйтэй болно. ”Бүлэглэг ухамсар бол монгол үндэстний соёл сэтгэцийн бүтцийн нэгэн гол элемент болох юм. Тэр нь ямар нэг овог аймаг, угсаа ястны хүмүүсийн өөрийн угсаа ястан ба оршин амьдарч байгаа орон нутагтаа болсон дотоодлог хайр сэтгэлгээгээр захицуулсан үзэл ухамсар болно. Бүлэглэг ухамсар бол нэг үндэстний бүхэл цогцот ухамсартай харьцуулж хэлсэн ухагдахуун юм. Түүнийг хувь цогцот ухамсартай харьцуулбал нэгэн хамтлаг чанартай ухамсар юм. Гэтэл хятад мэтийн бусад үндэстний хамтлаг ухамсартай харьцуулбал бас бүлэглэг чанартай байгаа юм. Иймээс бүлэглэг ухамсарт хамтлаг ухамсын шинж чанар ч оршиж байдаг. Бүлэглэг ухамсын үүсэл бүрэлдлийн уг үндсийг овог төрлийн нийгмээс хүрч хайх чухалтай юм. Учир нь, овог төрлийн байгуулал нь Монголын нийгмийн хөгжлийн нэг чухал шат үе болно. Овог төрлийн нийгэм эцэслэлмэгц монголчууд монгол үндэстэн болж бүрэлдсэн юм. Овог төрлийн байгуулал, нүүдлийн мал аж ахуй, нэгдэлтэй шүтээнгүй баларлаг шашин шүтлэг, буйд бөглүү байгалийн орчин тойрон зэрэг нь бүлэглэг ухамсын буй болж тогтвожихын үндэс шалтгаан юм” ⁵(Бунд.1990.x.38-39). Энэхүү бүлэглэг ухамсар алтай хэлтэн, түүний дотор монгол, казах, манж нарын ертөнцийг үзэх үзэл, ” . . . түүнд тулгуурлан ертөнцийг таньсан байдлын нийтлэг хэв загвар, нийтлэг үнэлэмжийн тогтсон хэмжүүрийг судлан тайлбарлах чухал сурвалж . . . ” ⁶(Баянсан.2002.x.98) бөгөөд -ууд, -үүд, -нууд, -нүүд, -чууд, -чүүд, -чуул, -чуул, -д, -с, -нар, -нэр болон -лар, -лер, -тар, -тер, -дар, -дер, түүнчлэн -са, -сэ, -си, -со, -та, -тэ, -ри бүтээврийг хэрхэн хэрэглэж ирсэн, хэрэглэж буй, яагаад төрлийн нэрээс эдгээрийн тусlamжтайгаар хэсгийн нэр үүсгэж харилцдаг хэл сэтгэлгээний аргатай болсон зэргийг ухаарч таних, тэгэхдээ ямар нэгэн тоо, тэр тусмаа олон тоотой холболгүй, хэлшинжлэлийн сэтгэлгээнд хэдийнээ эргэн харах шаардлагатай болсон ганц олон тооны айн талаархи онолын үндэслэлийг цорын ганц үнэн гэж ягштал баримтлахаас зайлсхийж, төрөл зүйлийн дотор багтсан хэсэг юмыг заадаг онцлогийг алтай хэлтний харилцааны тухайн орчинтой нягт холbon зөв таних нэгэн түлхүүр юм. Тийм учраас энэ тухайд олныг

⁴ Д.Бадмаанямбуу. Монгол хэлний тоо хийгээд хэмжээ илэрхийлэх ёс, түүний зүйтогтол. УБ.2004

⁵ Бунд.Монголчуудын бүлэглэг ухамсын тухай анхан шинжилгээ “Үүрийн цолмон. 1970

⁶ Ж.Баянсан.Соёл,хэл үндэстний сэтгэлгээ.УБ.2002

нуршилтгүй тул энд нь орхиод, гол зүйл, үндсэн санаагаа хураангуйлан илэрхийлбэл, алтай хэлний нэр үгийн тооны ай, хамаатуулах ай аль нь задлаг, нийлэг, задлаг-нийлэг аргаар илэрдэг бөгөөд нэр үгийн тооны айг илтгэх задлаг арга нь нэр үгэнд, нийлэг арга нь үйл үгэнд хамаатай, харин задлаг-нийлэг арга нэр үг, үйл үг хамтарсан нэгжид хамааралтай гэж үзэж байгаа юм. Түүнчлэн, олон зууны турш нэрийн тийн ялгалын нөхцөл гэгдсэн бүлэг бүтээврийг, нэрийн захируулах нөхцөл буюу үйл үгийн захиран найруулах айн илрэх хэрэглүүр, үйл үгээс нэрийг захиран найруулж өөртэйгөө холбон, тодорхой утгын нэгдэл бүхий нэгж үүсгээд, түүнд туулгуурлан, харилцааны хэрэглүүрийн үндсэн үүргээ гүйцэтгэх чухал арга гэж үзэж байна.

Номзүй

Д.Бадмаанямбуу.Монгол хэлний тоо хийгээд хэмжээ илэрхийлэх ёс, түүний зүй тогтол.УБ.2004

Ж.Баянсан.Соёл,хэл үндэстний сэтгэлгээ.УБ.2002

Бунд.Монголчуудын бүлэглэг ухамсын тухай анхан шинжилгээ. “Үүрийн цолモン”. 1970

Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц.Монгол хэлний үг нөхцөл хоёр.УБ.1968

Ш.Лувсанвандан.Хэл,харьцаа,тэмдэг.УБ.2005

SUMMARY

The suffixes in Altaic language, such as Kazakh: *-лар*, *-лер*, *-дар*, *-дер*, *-тар*, *-тер*; Manchu: *-са*, *-сэ*, *-си*, *-со*, *-та*, *-тэ*, *-ри* and Mongolian : *-нар*, *-эр*, *-чууд*, *-чүүд*, *-чуул*, *-чүүл*, *-нууд*, *-нүүд*, *-үүд*, *-д*, *-с* – are not the plural suffixes, but they are only the derivational suffixes.